

“Монгео” ХК-ийн ээлжит Хувь Нийлүүлэгчдийн

хурлын тэмдэглэл

Оролцсон нь :

- Н.Соёмбо – ТУЗ-ийн дарга
Х.Анар – ТУЗ-ийн гишүүн
Н.Тулга – ТУЗ-ийн гишүүн
Э.Норовринчин – ТУЗ-ийн гишүүн
М.Алтанцэцэг – ТУЗ-ийн гишүүн
Б.Нямдэлгэр – ТУЗ-ийн гишүүн
А.Ганцэцэг – Ня-бо
III Алтанцэцэг – Ажилтан
Ш.Амармэнд – Ажилтан
Ц.Оюунцэцэг – Ажилтан
Т.Батжаргал – Хөдөө ажлаар явсан

Хурлын ирц: Хувь Нийлүүлэгчдийн 2021 оны ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 30 ны өдрийн 10:00 цагт 67,63 хувийн ирцтэй өөрийн байранд эхлүүлэв.

Компанийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын даргад компанийн нийт хувьцааны 35544 ширхэг хувьцааг эзэмшигч Н.Соёмбо өөрийн нэрийг дэвшүүлж хуралд оролцогсдын 100 хувийн саналаар сонгогдлоо.

Мөн хурлын нарийн бичгийн даргад ТУЗ-ийн гишүүн Э.Норовринчингийн нэрийг дэвшүүлж мөн нийт хуралд оролцогсдын 100 хувийн саналаар дэмжигдлээ.

Хурлын нарийн бичгийн дарга Э.Норовринчин хурлын дэгийг танилцуулсан болно.

Хэлэлцсэн нь :

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн эцсийн тайлангийн талаар ТУЗ-ийн хурлын шийдвэрийг хэлэлцэж батлах,
2. Аудиторын дүгнэлтийг хэлэлцэх,

3. Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр улсын болон орон нутгийн чанартай зохион байгуулагдах ажилд идэвхтэй оролцох, шаардагдах төсөв төлөвлөгөөг тооцож тухай бүрт нь ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлэх,

4. Тус компанийн эзэмшлийн ХУД-ийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлал бүхийн 8,08 га газрыг хүнс, хаа-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн болон бусад зорилгоор ашиглах төсөл хэрэгжүүлэхийг үе шаттайгаар эхлүүлэх ажлыг зохион байгуулахыг компанийн удирдлагад үүрэг болгох,

5. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх санхүүгийн тогтвортой байдлыг хангах, ажлын байр нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилготойгоор их хэмжээний зээл авах, гэрээ хэлцэл байгуулахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрөх,

Хурлын явц :

Хурлын дэгийг баримтлан компанийн гүйцэтгэх захирал М.Алтанцэцэг тайлант оны үйл ажиллагааны тайланг сонсголоо. Компани батлагдсан хууль, дүрэм, журмыг баримтлан мөн 2021 онд хуралдсан Хувь Нийлүүлэгчдийн хуурлаас гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж ирлээ. Өнгөрсөн хугацаанд шаардлагатай ажлуудын шийдвэр гаргах үндэслэлийг ТУЗ-ийн хуралд хэлэлцүүлж зохих шийдвэрүүдийг гарган ажиллаж Удирдах байгууллага Санхүүгийн Зохицуулах Хороо, Хороогийн биржтэй хамтран ажилласан болно.

Одоогоор компанид 8 хүн ажиллаж байна. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулахгүй байгаа ч гэлээ түрээсийн үйл ажиллагаагаа тодорхой хэмжээгээр өргөтгөн ажиллалаа.

Өнгөрсөн онд компанийн барилгынхаа өрөөнүүдийг үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар 12 аж ахуй нэгж, 2 иргэнтэй түрээсийн гэрээтэй ажилласан билээ. Сар бүр компанид бүрдэх түрээсийн орлогыг цаг хугацаанд нь бүрэлдүүлж зохих түвшинд зардлаа хуваарилан ажилласан байна.

Цар тахлын цаг үед түрээслэгч нарын ажлын байрыг хадгалах зорилгоор зарим түрээслэгч нарын түрээсийн төлбөрийг нилээд хугацаанд хөнгөлж ажилласан.

Компанийн нягтлан бодогч А.Ганцэцэг санхүү татварын талаар дэлгэрэнгүй танилцууллаа.

А.Ганцэцэг :Тайлант хугацаанд өмнө онуудад хуримтлагдсан байсан НӨАТ-ын /4,544.1/ төгрөгийг, ХАОАТ-ын /3,716.3/төгрөгийг ,ҮХЭХАТ-ын /1,294.0/төгрөгийг төлж барагдуулсан байна. Мөн нийгмийн даатгалын шимтгэлийн үлдэгдэл өр төлбөргүй бөгөөд, компанийн эзэмшлийн ХУД-ийн болон СХДүүргийн газрын төлбөрийн өрийн үлдэгдэлгүй байна.

Мөн компанийн 2021 оны жилийн санхүүгийн тайландаа “Гэрэлт Хөхийн Тэнцвэр Аудит ХХК”-р дүгнэлт гаргуулсан болно.

Тус аудитын байгууллага : Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хамгаалагдсан гэж бид итгэж байна.

Түүнчлэн компани нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Монгол улсад мөрдөж байгаа Нягтлан Бодох Бүртгэлийн зарчмууд болон Сангийн сайдын тушаал , Санхүүгийн Зохицуулах Хорооны тогтоолоор баталсан нягтлан бодох бүртгэлийн заавартай нийцэж байна гэж дүгнэжээ хэмээн аудиторын дүгнэлтийг танилцууллаа.

Санал шүүмжлэл :

М.Алтанцэцэг : Өнгөрсөн оны үйл ажиллагааны болон санхүү татварын тайлангийн талаар сонсож танилцлаа. Одоо бид нэгэнт үндсэн үйл ажиллагааны чиглэлийг баримтлахгүй байгаа тул компанийн эзэмшлийн газар дээр төсөл хэрэгжүүлж өөрийн орлоготой больёо гэж бодож байна. Энэ талаар нэлээд хугацаанд чамгүй ч ярилцлаа. Юуны өмнө хэлсэн ярьснаа ажил хэрэг болгох хэрэгтэй байна.

Н.Соёмбо : Гүйцэтгэх захирлын ярьсан болон дэвшүүлсэн саналыг хурал болох бүрт ярьж байна. Компанийн эзэмшлийн ХУД-ийн болон СХД-ийн газар дээр энэ ондоо багтааж ямар нэгэн үйл ажиллагаа явуулах шаардлагатай байна. Шийдлийг олох нь зүйтэй болов уу?

Э.Норовринчин :

Тайлант хугацааны үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайлангуудтай танилцлаа. Одоо бид орлого олох, санхүүгийн тал дээр ахиц гаргах ажлуудыг хийж эхлэх нь зүйтэй гэж бодож байна.Хурлаас гарах шийдвэрүүдийг хүлээн авч хэрэгжүүлэх тал дээр өөрийн зүгээс хамтран ажиллана гэж бодож байна.

М.Алтанцэцэг : Шинэлэг зүйл хийх хэрэгтэйг маш сайн ойлгож байгаа. Энэ тал дээр хөрөнгө мөнгөний асуудал гарч ирдэг. Энэ тал дээр судалж үзсэн. Компанид ч тэр , улсад ч тэр хэрэгтэй, бидэнд ашигтай бизнес төлөвлөгөө, төслийг хөрөнгө оруулалтын зээл авч ч хэрэгжүүлж болох юм билээ.Үүний тулд хэрэгжүүлж болохоор ашиг алдагдлыг маш сайн тооцоолсон төсөл, төлөвлөгөө байх шаардлагатай.

Н.Тулга: Компанийн ТУЗ-ийн гишүүн Б.Нямдэлгэрийн боловсруулсан “Малын тэжээл бордоо үйлдвэрлэх” төслийг ХУД-ийн 12 р хорооны нутагт байгаа 8,08 га газрыг түшиглэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулбал зүгээр байх.Үүний тулд хурлаас шийдвэр гаргах шаардлагатай болов уу ?

Х.Анар : Компанид ч эсвэл эзэмшлийн газарт ч болов үйлдвэрлэл үйлчилгээний ажил эрхлэх зайлшгүй шаардлага байна. Энэ хурлаас тодорхой шийдэл гаргах нь зүйтэй гэж санагдаж байна.

Б.Нямдэлгэр: Өнгөрсөн хугацааны компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн жилийн эцсийн тайлантай танилцлаа. Тодорхой зүйл дээр ахиц гарсан нь сайшаалтай.

Тухайлбал газрын төлбөрийн өргүй, ҮХЭХАТ-ийн өргүй, түүнчлэн НДШ-ийн өргүй байна. Цаашдаа компанийн эзэмшлийн газар дээр Хүнс , ХАА-н чиглэлээр бизнесийн үйл ажиллагаа эхлүүлбэ гэсэн санал маш зүйтэй санагдлаа. Хурлаас гарах шийдвэрийг хүндэтгэн хүлээн авна.

А.Ганцэцэг: Компанийн эзэмшлийн газар дээр хэрэгжүүлэх малын тэжээл үйлдвэрлэх төслийг нягтлан хүний хувьд судалж үзсэн. Ер нь боломжийн гэж бодогдсон шүү. Ер нь монгол хүнийг махгүйгээр төсөөлөхийн аргагүй.

Мах дагаж мал байх учир малын тэжээл бордоо үйлдвэрлэх санаа, төслийг хэрэгжүүлэх тал дээр зоригтой шийдвэр гарган энэ ажлыг эхлүүлбэл нэг их алдахгүй болов уу гэж үзэж байна. Хурлаас гарах шийдвэрийг хүлээн авч, хүндэтгэн үзнэ.

Н.Соёмбо : Компанийн санхүүгийн чадавхийг сайжруулах зорилгоор боломжит төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх тал дээр ТУЗ-ийн гишүүд , компанийн удирдлагатай хамтран ажиллаж шийдэл олох гарцыг нээж ажиллах хэрэгтэй байна гэснээр санал шүүмжлэлийг тасаллаа.

Шийдвэрлэсэн нь :

1. Тайлант хугацааны компанийн үйл ажиллагааны болон жилийн санхүүгийн тайлангуудыг зөвшөөрөхөөр,
2. Аудиторын дүгнэлтийг зөвшөөрөхөөр,
3. Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр улсын болон орон нутгийн чанартай зохион байгуулагдах ажилд идэвхтэй оролцох, шаардагдах төсөв төлөвлөгөөг тооцож тухай бүрт нь ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлэн шийдвэр гаргахаар,
4. Тус компанийн эзэмшлийн ХУД-ийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлал бүхий 8,08 га газрыг хүнс, хаа-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн болон бусад зорилгоор ашиглах төсөл хэрэгжүүлэхийг үе шаттайгаар эхлүүлэх ажлыг зохион байгуулахыг компанийн удирдлагад үүрэг болгохоор,

5. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх санхүүгийн тогтвортой байдлыг хангах, ажлын байр нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилготойгоор их хэмжээний зээл авах, гэрээ хэлцэл байгуулахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрөхөөр,

6. Хурлаас холбогдох шийдвэрүүдийг гаргахаар тус тус шийдвэрлэв.

Хурлыг 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 12 цаг 35 минутанд дуусгав.

Тэмдэглэл хөтөлсөн...../Н.Тулга /

Танилцсан :

ТУЗ-ийн дарга...../Н.Соёмбо/

ТУЗ-ийн гишүүн...../Х.Анар/

ТУЗ-ийн гишүүн...../М.Алтанцэцэг/

ТУЗ-ийн гишүүн...../Н.Тулга/

ТУЗ-ийн гишүүн...../Б.Нямдэлгэр/

ТУЗ-ийн гишүүн...../Э.Норовринчин/

Нягтлан бодогч/А.Ганцэцэг/

Компанийн ажилтан...../Ш.Алтанцэцэг/

Компанийн ажилтан...../Ш.Амармэнд/

Компанийн ажилтан...../Ц.Оюунцэцэг /